



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/201

Улаанбаатар хот

Статистикийн улсын байцаагчийн
дүрмийг шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Статистикийн улсын байцаагчийн дүрмийг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Статистикийн улсын байцаагчийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Ч.Цэвэгдоржид үүрэг болгосугай.
3. Дүрмийг шинэчлэн баталсантай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2011 оны 1/199 дүгээр тушаалын 1, 2, 3, 9 дүгээр хавсралтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.АРИУНЗАЯА

Үндэсний статистикийн хорооны даргын
2017 оны 12 сарын 01 өдрийн
А/201 тушаалын 01 дүгээр хавсралт



СТАТИСТИКИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын “Статистикийн тухай”, “Зөрчлийн тухай” хууль болон бусад хууль, тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж хэрэгжүүлэх, тооллого, судалгаа, мэдээ, тайлангийн үнэн зөв, шуурхай байдлыг хангуулах, аж ахуйн нэгж, байгууллага, статистик нэгжүүдийн мэдээллийн хамралтанд статистикийн улсын байцаагч хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Статистикийн улсын байцаагч (цаашид улсын байцаагч гэнэ) нь статистикийн мэдээлэл, судалгаа, тайлан тэнцлийн үнэн зөв, шуурхай байдалд мэргэжлийн хяналт тавих, Монгол Улсын “Статистикийн тухай”, “Зөрчлийн тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, мэдээлэл, тооллого, судалгааны үйл ажиллагаанд гарсан зөрчлийг илрүүлэн, үр дагаварыг арилгуулна.

1.3. Мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага, туршлагыг харгалзан статистикийн байгууллагын ажилтнуудад Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар Статистикийн улсын байцаагчийн эрх олгоно.

1.4. Албан ёсны статистикийн мэдээлэл гаргах үйл ажиллагаанд оролцдог яам, агентлаг, төрийн бусад байгууллагын санал болгосноор тухайн асуудлыг хариуцсан албан хаагчид Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар Статистикийн улсын байцаагчийн эрх олгож болно.

1.5. Улсын байцаагч нь албан шаардлага, шийтгэлийн хуудас болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг хэрэглэнэ. Шийтгэлийн хуудас нь үнэт цаасанд тооцогдоно. Байцаагчийн хэрэглэх албан шаардлага, үнэмлэх, тэмдгийг Үндэсний статистикийн хорооноос, шийтгэлийн хуудсыг төв, орон нутгийн санхүүгийн албадаас олгоно.

1.6 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.6.1 “Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан” гэж эрх бүхий албан тушаалтны шууд харьяалах дээд шатны албан тушаалтныг ойлгоно.

1.6.2 “Эрх бүхий албан тушаалтан” гэж зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг ойлгоно.

1.6.3 “Зөрчил” гэж хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

1.6.4 “Шийтгэлийн хуудас” гэж зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах шийдвэр гэж ойлгоно.

Хоёр. Статистикийн улсын байцаагчийн үйл ажиллагаанд мөрдөх зарчим

2.1 Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 13, 15 дугаар зүйл, “Зөрчлийн тухай” хуулийн 1.2, 1.3 дугаар заалт, Статистикийн улсын байцаагчийн дүрэм, “Төрийн

захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Статистикийн байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм” болон бусад хууль, тогтоомжийг ёсчлон дагаж шударга, ёс зүйтэй, хариуцлагатай ажиллана.

2.2 Улсын байцаагч нь үйл ажиллагаа явуулахдаа аливаад бодитой хандах, зохисгүй нөлөөнөөс ангид хараат бус байж төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, өрх, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтэд задруулахгүй байна.

2.3. Улсын байцаагч нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ.

Гурав. Статистикийн улсын байцаагчийн эрх

3.1. “Статистикийн тухай”, “Зөрчлийн тухай” хууль болон бусад эрх зүйн актын биелэлтийг хянаж шалгана;

3.2. Статистикийн мэдээлэгч өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагууд, албан ёсны статистикийн болон захиргааны статистикийн мэдээлэл, тооллого, судалгааг батлагдсан буюу зөвшөөрөгдсөн үзүүлэлт аргачлалын дагуу тогтоосон хугацаанд нь үнэн зөв өгч байгаа эсэхийг хянаж шалгана.

3.3 Өөрийн харьяалах нэгжийн үйл ажиллагаанд засаглалын болон эрсдэлийн үнэлгээ хийнэ.

3.4. Хяналт шалгалтын ажилд зайлшгүй шаардагдах баримт материал, тайлбар, лавлагааг холбогдох албан тушаалтнаар гаргуулан авна. Нотлох баримтыг бэхжүүлж, бүрдүүлнэ.

3.5. Хяналт шалгалтаар илэрсэн алдаа, дутагдал, эрсдэлийг арилгуулах шаардлага, үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтанд өгч, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргуулан авч хэрэгжилтэд хяналт тавина.

3.6. Хяналт шалгалт явуулах, дүгнэлт гаргах ажилд холбогдох ажилтнуудыг тухайн байгууллагын удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр татан оролцуулна.

3.7. Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллага, өрх, хувь хүний өгсөн мэдээ, тайлан, мэдээллийг анхан шатны бүртгэлтэй нь тулган шалгаж, дутуу, алдаатай, бодит бус байгаа тохиолдолд холбогдох этгээдээс тайлбар гаргуулан авна.

3.8. Статистикийн улсын байцаагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлж, албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зардлыг харьяалах байгууллагаас олгоно.

Дөрөв. Статистикийн улсын байцаагчийн үүрэг

4.1. Албан ёсны статистикийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг өмчийн бүх төрөлд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, өрх, хувь хүн, гадаадад үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын хуулийн этгээдэд мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт, тавьж, мэргэжлийн зөвлөмж, туслалцаа үзүүлнэ.

4.2. Албан ёсны статистик мэдээлэл, судалгаа, тайлангийн хамралт, үнэн зөв, шуурхай байдлыг шалгаж, илэрсэн алдаа, дутагдлын талаар тухайн байгууллагын удирдлагад танилцуулж, үр дагаврыг арилгуулах, залруулах арга хэмжээ авна.

4.3. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг бүртгэх, шалгах, харьяаллын дагуу шилжүүлэх, прокурорын байгууллагад мэдэгдэх, нотлох баримтыг бэхжүүлэх, бүрдүүлэх, шийдвэрлэх, удирдах албан тушаалтнаар хянуулах, харьяалах прокурорын байгууллагад хуульд заасан хугацаанд тайлагнана.

4.4 Аж ахуйн нэгж, байгууллага, өрх, хувь хүн албан ёсны статистикийн мэдээ, тайлан, тооллого, судалгааны мэдээллийг хугацаанд нь гаргаж ирүүлээгүй байх, ташаа мэдээлсэн, мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд “Зөрчлийн тухай” хууль болон холбогдох эрх зүйн актын дагуу арга хэмжээ авна.

4.5. Орон нутаг болон нийслэлд ажиллаж буй улсын байцаагч нар хамтран ажиллах төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны, хагас жилийн төлөвлөгөөний биелэлт, тайланг 07 дугаар сарын 07-ны, жилийн төлөвлөгөөний биелэлт, тайланг 12 дугаар сарын 28-ны дотор уг ажлыг хариуцсан нэгжид ирүүлж байна.

Тав. Статистикийн улсын байцаагчид хориглох зүйл

5.1. Хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүргийг биелүүлэхдээ хүнд суртал гаргах, чирэгдүүлэх, дарамтлах, хууль тогтоомжид нийцэхгүй, хууль бус зүйлийг шаардах;

5.2. Аливаа асуудлыг шийдвэрлэхэд бусдыг айлган сүрдүүлэх, нэр төрийг нь гутаах, басамжлан доромжлох, зүй бус үг хэрэглэх;

5.3. Хяналт, шалгалт хийх явцад бусдын нөлөөнд автах, эрхшээлд нь орж болзошгүй эрсдэл бий болох аливаа харилцаанаас зайлсхийх;

5.4. Хууль бус үйлдлийг нуун дарагдуулах, албан тушаалаа урвуулан ашиглах, албан тушаалын давуу тал, боломжийг хувийн ашиг сонирхолд нийцүүлэн хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор ашиглах.

Зургаа. Улсын байцаагчийн ажлыг дүгнэх, урамшуулах

6.1. Улсын байцаагчдын ажлыг дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэнэ. Үүнд:

6.1.1. “Статистикийн тухай”, “Зөрчлийн тухай” хууль болон бусад эрх зүйн актын биелэлтийг хянаж, илрүүлсэн зөрчил, түүний үр дагаврыг арилгасан үр дүн:

- Албан ёсны болон захиргааны тогтмол мэдээлэлд гарсан алдаа;
- Түүвэр судалгааны анхдагч мэдээлэлд гарсан алдаа;
- Тооллогын анхдагч мэдээлэлд гарсан алдаа;
- Хэвлэмэл бүтээгдэхүүнд гарсан алдаа;
- Цахим мэдээлэлд гарсан алдаа;
- Боловсруулсан баримт бичигт гарсан алдаа;

6.1.2. Статистикийн мэдээ тайланд хамрагддаггүй, тасалж хожимдуулдаг зөрчлийг арилгуулан тогтмол ирүүлдэг болгон хэвшүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо:

- Хүрээнд орсон боловч хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тоо;
- Түүвэр судалгаанд сонгогдсон боловч хамрагдаагүй нэгжийн тоо;
- Мэдээ, тайланг тасалж хожимдуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын тоо;
- Шинээр мэдээнд хамруулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо;
- Хүрээнд орсон боловч хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээнд хамруулсан нэгжийн тоо;
- Мэдээ, тайланг тасалж хожимдуулдаг аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээ, тайлангаа тогтмолжуулсан нэгжийн тоо.

6.1.3. Авсан арга хэмжээ

- Шаардах хуудасны тоо;
- Бичилт хийсэн шийтгэлийн хуудасны тоо;
- Шийтгэлийн мөнгөн дүн, үүнээс барагдуулсан;
- Сахилгын арга хэмжээ авагдсан хүний тоо;
- Хуулийн байгууллагад шилжүүлсэн хүний тоо;

- Мэдээллийн зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн дүн.

6.2. Жилийн ажлын үр дүнгээр тэргүүлсэн улсын байцаагчийг урамшуулах асуудлыг ҮСХ-ны Даргын Зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ.

Жилийн ажлын үр дүнг харгалзан улсын байцаагч нарыг “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар урамшуулж болно.

6.3 Тэргүүний улсын байцаагчийн туршлагыг бусдад танилцуулах, нэвтрүүлэх арга хэмжээ зохион байгуулна.

6.4 Улсын байцаагч нарын ажлын үр дүн, идэвх санаачилга, илрүүлсэн зөрчлийг харгалзан аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны болон статистикийн төв, орон нутгийн байгууллагын шагналд тодорхойлно.

Долоо. Хүлээлгэх хариуцлага

7.1 “Статистикийн тухай”, “Зөрчлийн тухай” хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн улсын байцаагчийн үйлдэл нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

7.2 “Статистикийн тухай”, “Зөрчлийн тухай” хууль болон бусад холбогдох эрх зүйн актаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн статистикийн мэдээлэгчид дараах хариуцлага хүлээлгэнэ:

7.2.1 Статистикийн мэдээ, тайлан, тооллого, судалгааны мэдээллийг санаатайгаар буруу мэдээлсэн, нуун дарагдуулсан үйлдэл нь эрүүгийн хэргийн шинжгүй бол “Зөрчлийн тухай”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.2.2 Статистикийн мэдээ, тайлан, тооллого, судалгааны мэдээллийг санаатайгаар буруу мэдээлсэн, нуун дарагдуулсан үйлдэл нь эрүүгийн хэргийн шинжтэй бол буруутай этгээдийг хуулийн байгууллагаар шалгуулах хүсэлтээ харьяалах прокурорын байгууллагад гаргаж шийдвэрлүүлнэ.

7.2.3 Яам, газар, агентлаг, аймаг, нийслэл дүүргээс гаргасан албан ёсны болон захиргааны статистик мэдээлэлтэй холбоотой шийдвэр нь “Статистикийн тухай” хууль болон бусад эрх зүйн акттай нийцээгүй бол энэ тухай Хорооны удирдлагад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

___оОо___